



**МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2025.04.18 № 01/2024
танай 2025.04.03 -ны № 15 -т

Хариу хүргүүлэх тухай

Танаас 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуулттай танилцан дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1.Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого, үйл ажиллагаанд “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоох” талаар тусгагдсанаас гадна Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 12 дугаар тогтоолын 2 дахь заалтаар 2025 онд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор шинэчлэн тогтоохоор шийдвэрлэсэн.

Дээрх хэлэлцээр болон тогтоолд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох асуудлаар тооцоолол хийж, санал боловсруулах гурван талын хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, өөрчлөх саналыг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороонд төлөөлөл бүхий аль нэг тал, эсхүл талууд хамтран гаргаж болно.” гэж, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо энэ хуулийн 4.2-т заасан хүчин зүйлийг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жилд нэг удаа тогтоох бөгөөд энэ хуулийн 6.1, 6.2-т заасан саналын дагуу шинэчлэн тогтоож болно.” гэж тус тус заасны дагуу ажлын хэсгээс танилцуулсан холбогдох хүчин зүйлс болон талуудын саналыг харгалзан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

2.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоосноор аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин

хөлс авдаг ажилтны цалин хөлс нэмэгдэх, зарим төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэх зэрэг эерэг үр дагавартай. Тухайлбал хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авч байгаа 47.5 мянган хүний тэтгэмжийн хэмжээ 93.4 мянган төгрөгөөр, жирэмсний, амаржсаны тэтгэмж авч байгаа 29.5 мянган хүний тэтгэмж 167.5 мянган төгрөгөөр, ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа 18.6 мянган хүний тэтгэмж 182.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

Нөгөө талаас сайн дурын даатгуулагчийн шимтгэл төлөлт, ажил олгогчийн цалингийн зардал тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ. Тухайлбал нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд дараах нөлөө үзүүлэхээр байна. Үүнд:

Улсын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлөх 81.4 мянган даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл 4.7 тэрбум төгрөгөөр нэмж төлөгдөнө. Үүнд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.17, 21.21.2, 21.22, 21.23 дахь хэсэгт заасан цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх эсхүл эцгийн шимтгэлийг бүрэн хэмжээгээр, гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, малчин, туслах малчны төлөх шимтгэлийн 50 хувийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс төлөхөөр заасан байдаг.

Нийгмийн даатгалын сангаас хариуцан төлөх 18.9 мянган даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл 2.0 тэрбум төгрөгөөр нэмж төлөгдөхөөр байна. Үүнд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.19, 21.21.1 дэх заалтад заасан хөдөлмөр эрхлээгүй, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчийн шимтгэлийг бүрэн, гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн шимтгэлийн 50 хувийг нийгмийн даатгалын сангаас хариуцан төлөхөөр заасан байна.

Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого нийт 129.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Үүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалинтай даатгуулагч болон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс дээгүүр цалинтай Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон ажил олгогч сар бүр төлж буй нийт 295.0 мянган даатгуулагчийн шимтгэлийн орлого 101.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.

Түүнчлэн сайн дураар даатгуулсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон нийгмийн даатгалын шимтгэл төлдөг 134.2 мянган даатгуулагчийн шимтгэл 28.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага нийт 38.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.

Үүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 21.2 дахь хэсэгт заасны дагуу тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн доод хэмжээ авдаг 1,498 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээ 66.0-132.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр 2.4 тэрбум төгрөгөөр зардал нэмэгдэнэ.

Түүнчлэн Нийгмийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар алдсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийн зардал нийт 36.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

3. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2022 онд 6,065 хүний 4.8 тэрбум төгрөг, 2023 онд 3,204 хүний 7.0 тэрбум төгрөг, 2024 онд 4,346 хүний 7.1 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.


Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32.1-д заасны дагуу “Хуульд өөрөөр заагаагүй бол гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн нэг сарын хэмжээ нь нэг сард ногдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байна.” гэж заасныг мөрдөж байна.

Мөн тус хуулийн 32.3.-д “Энэ хуулийн 21.2.1, 21.2.3, 21.3.1, 22.5-д заасан гадаад ажилтан, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, спортын байгууллагад гэрээгээр ажиллах эмч, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжлийн багш, дасгалжуулагч авч ажиллуулах ажил олгогчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө.” гэсний дагуу дурдсан салбарын ажилтнуудыг ажлын байрны төлбөрөөс чөлөөлдөг.

Засгийн газрын 2025 оны “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх” тухай 31 дүгээр тогтоолоор 2025 онд 52 аж ахуйн нэгж, байгууллагын 14737 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхөөр болсон.

Түүнчлэн Засгийн газрын 2023 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, бүртгэлийг хөтлөх журам”-ыг баримтлан тодорхой салбарын ажиллах хүчийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг зохицуулж байна. 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 125 байгууллагын 4239 гадаад иргэнийг ажлын байрны төлбөрөөс хөнгөлсөн болно.

Хүндэтгэсэн,



Л.ЭНХ-АМГАЛАН